



**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”**  
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027  
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,  
Цахим шуудан: info@erdenetmc.mn,  
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.08.19 № 905-134-12/5442

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Баримт бичиг хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/20240101799 дугаартай “Төмөр замын 10, 29-р салаа замын их засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцсон “Дорнын харгуй” ХХК-аас гомдол гаргасны дагуу хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгүүдийг хүргүүлж байгааг хүлээн авна уу. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар,
2. Захиалагчийн үнэлгээний хороо томилсон тушаал,
3. Захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг,
4. Оролцогчдын ирүүлсэн тендер,
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл,
6. Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл,
7. Шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр,
8. Холбогдох бусад баримт бичиг.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407020550



## “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

АДВАН-ОР-19 № ТБ-134-12/5443

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Захиалагчийн шийдвэр гаргах хугацааг  
сунгах тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Төмөр замын 10, 29-р салаа замын их засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240101799 дугаартай тендерт оролцсон “Дорнын харгуй” ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-т заасны дагуу гомдол гаргасан.

Тус гомдлын дагуу Сангийн яам 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 03/6763 дугаартай албан бичгээр хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9-д заасан шийдвэр гаргасан тул хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт заасныг үндэслэн захиалагчийн шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хоногоор сунгаж байгааг мэдэгдье.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407020552



## “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.08.19 № ТБ-134-12/57444

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн  
тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/20240101799 дугаартай “Төмөр замын 10, 29-р салаа замын их засварын ажил”-ын тендер шалгаруулалтад оролцсон “Дорнын харгуй” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-т заасны дагуу гомдол гаргасан тул Сангийн яам 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 03/6763 дугаар албан бичгээр хуулийн 59.6 дахь хэсгийг үндэслэн гүйцэтгэгч сонгох ажиллагааг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн болохыг үүгээр мэдэгдье.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407020554



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН  
ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.08.13 № 03/6763

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Тендер шалгаруулалтыг түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан ЭҮТӨҮГ/20240101799 дугаартай “Төмөр замын 10, 29-р салаа замын их засварын ажил”-ын тендер шалгаруулалтад оролцсон “Дорнын харгуй” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
3. Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
4. Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
6. Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
7. Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
9. Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
10. Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг анхаарна уу.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

9766012764